

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, "МОНГОЛБОЛГАРГЕО" ХХК НАРЫН ХООРОНД БАЙГУУЛСАН
"БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, УУРХАЙ АШИГЛАХ, ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ДЭД
БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ" 2022/88 ТООТ ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН
БИЕЛЭЛТ /2022 ОН/**

2023 оны 2.дүгээр сарын 06

д/д	№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргийн биелэлт	Гүйцэтгэл / тайлан/	Үнэлгээ /хувь/
1	2	3	4	5
1	3.1.1	Үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлэх;	Тайлант жилд уурхайн хэвийн үйл ажиллагаа явуулахад сум орон нутгийн иргэд, хуулийн этгээд, төрийн байгууллагын зүгээс учруулсан элдэв саад бэрхшээл, хэл ам гараагүй тул Засаг дарга, Иргэдийн хуралд оруулж шийдвэрлүүлэх асуудал гаргаагүй болно.	100%
2	3.1.2	Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтад хамруулах талаар орон нутгийн хөдөлмөрийн байгууллагатай хамтарч ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах;	Тус компани нь анх үүсгэн байгуулагдсан цагаасаа орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг байнга дэмжиж ажилласаар ирсэн. Энэ ажлынхаа хүрээнд өөрийн уурхай дээр болон орон нутгийн ажлын байрны сургалтанд байнга хүмүүсээ сургаж дадлагажуулах ажлыг зохион байгуулж, сумын ЗДТГ-тай хамтран уурхайд шинээр ажилчид авах асуудлыг нээлттэй зохион байгуулах арга хэмжээ авсан.	70%
3	3.1.3	Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах;	Жил бүр орон нутгаас ажилд авсан иргэдийг ажлын байран дээр сургалт явуулж дадлагажуулах, мэргэшүүлэх, ажлын байрны ХАБЭА-н аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол зохион байгуулж ирсэн. /3.1.4-т тусгасан болно./	100%

4	3.1.4.	Ажиллах хүчнийхээ 50-иас доошгүй хувийг орон нутгаас ажиллуулах, Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын мэдээллийн санд бүртгэлтэй иргэдээс ажилд авах	Компанийн нийт ажиллагсадын 90% буюу 54 ажилчин Баянхонгор аймгийн уугуул иргэд байдаг. 2022 онд Галуут сумаас 12 ажилчин авч ажлуулсан. Үүнээс: 4 ажилтанг авто-ачигчын сургалтанд суулгаж мэргэжлийн үнэмлэхтэй болгосон.	100%
5	3.1.5	Хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ болон үйл ажиллагааныхаа талаар тухайн аймаг (сум)-ийн иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч байх	Тус уурхай нь Галуут сумын Сүмбэрийн багийн нутагт байрладаг. Уурхайн бүс нутагт амьдардаг малчин, ард иргэдэд үйл ажиллагааныхаа талаар тогтмол танилцуулж мэдээлэл солилцдог. 2022 онд уурхайд хийж гүйцэтгэх ажил, хөрөнгө оруулалт, нөхөн сэргээлт, байгаль орчныг хамгаалах талаар хийж гүйцэтгэх ажлуудыг тухай бүр нь нутгийн иргэдэд мэдээлэл өгч саналыг нь тусгаж ажилласан.	70%
6	3.1.6	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, зохих байгууллагаар хянуулсан уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ зэргийг биелүүлж ажиллах, тухайн жилийн байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөөнд тусгагдсан техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг бүрэн хийж гүйцэтгэх	Монгол улсын холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажилласан. Үүнд: ТЭЗҮ, БОНБНҮ, тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, зөвшөөрөл, гэх мэт	100%
7	3.1.8	Гамшгийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх;	Галуут сумаас аймгийн төв явдаг төв замыг үер усны гамшгаас хамгаалах зорилгоор засварлах ажилд 2 ачааны машин, 1 авто ачигчийг гарган шатах тослох материалыг өөрийн зардлаар бүрэн санхүүжүүлж 2 ээлжээр ажлуулсан. Мөн сумын төвийн хогийн цэгийг цэвэрлэж тохижуулсан.	100%

8	3.1.9	Гурван талууд бүгд зөвшөөрсөн тохиолдолд зохион байгуулалтад орсон бичил уурхайн нөхөрлөлүүдтэй гурвалсан гэрээний үндсэн дээр талбай олгох, хамтран ажиллах; /Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор батласан "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 4.3 дэх заалт/	Гурван талууд бүгд зөвшөөрсөн тохиолдолд зохион байгуулалтад орсон бичил уурхайн нөхөрлөлүүдтэй гурвалсан гэрээний үндсэн дээр талбай олгох, хамтран ажиллах хүсэлт ирээгүй тул гэрээ хийх шаардлага гараагүй.	100%
9	3.1.10	Эрх бүхий байгууллага албан тушаалтнаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлж ажиллах.	Аймгийн мэргэжлийн хяналтын байцаагчийн 2022 оны 06-р сарын 05-ний өдрийн 05-05-015/19 тоот албан шаардлагын дагуу уурхайн эзэмшлийн зам талбайн аюулгүй байдлыг ханган тэмдэг тэмдэглэгээг байршуулж аюулгүй бүсийг тогтоон урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажилласан. Уурхайн талбайд мэдээллийн самбар, урьдчилан сэргийлэх дохио санамж анхааруулга аюулгүй тэмдэг хийж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажилласан.	100%
10	3.1.11	Уул уурхайн ил тод байдлыг бий болгож, олборлосон баялаг, татвар төлбөрөө тайлагнаж байх,	Төрийн холбогдох байгууллагуудад тайлангаа тогтмол хуулийн хугацаанд ил тод гаргаж өгдөг. /АМНАТ-54,3 сая, ХХОАТ-33,0 сая/ Бусад татварыг 3.1.16-д тусгасан болно.	100%
11	3.1.12	Олборлосон металлыг Баруун бүсийн үнэт металлын сорьц тогтоох лабораториор баталгаажуулж, Монгол банк болон эрх бүхий арилжааны банкинд тушааж байх;	Олборлосон металлыг Баруун бүсийн үнэт металлын сорьц тогтоох лабораториор баталгаажуулж, Аймгийн ХААН банкинд тушаадаг. /Нийт 3 удаа 6 кг металл тушаасан./	100%

12	3.1.13	Уурхай эрхлэхэд шаардагдах Ашигт малтмалын тухай хуулийн 35-р зүйлд заасан бичиг баримтын бүрдлийг бүрэн хангасан тохиолдолд ажлаа эхэлж байх.	Ашигт малтмалын тухай хуулийн 35-р зүйлд заасан бичиг баримтын бүрдлийг хангаж ажилласан.	100%
13	3.1.14	Нийгмийн хариуцлагынхаа хүрээнд аймаг сум орон нутгийн өмнө тулгамдаж байгаа аливаа асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх талаар санал санаачилга гаргах	Нийгмийн хариуцлагынхаа хүрээнд гэрээний дагуу аймагт 50 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Галуут сумын соёлын төвд иж бүрэн цахилгаан хөгжим тоног төхөөрөмж авч өгсөн, Мөн тохижилтонд сандал ширээ хурлын индэр авахад 10 сая төгрөгийн тусламж үзүүлсэн. Мөн сумын өвөлжилтийн бэлтгэлд зориулж 100 тн нүүрс өгсөн.	100%
14	3.1.15	Орон нутагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнтэй ижил төрлийн бараа бүтээгдэхүүнийг гадна бусад зах зээлээс авахгүй байх	Арвижих худалдааны төв болон Есөн-Эрдэнэ зах, Цэлмэг-Өглөө, Хас сэлбэгийн төвтэй хамтарч ажилладаг.	100%
15	3.1.15.1	Мах, сүү, хүнсний ногоог 100% тухайн орон нутгийн иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан худалдан авах	-Баянхонгор аймгийн Есөн-Эрдэнэ ХХК 32 сая төгрөгийн хүнс бараа худалдан авсан. Уурхай орчмын бүсийн иргэдээс хонь 6-сая, үхэр-13 сая, төгрөгний мал мах худалдаж авсан. - 2022 оны тайлангийн жилд Баянхонгор аймгийн аж ахуйн нэгж болон хувь хүмүүсээс 98 сая төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн, бараа материал, сэлбэг хэрэгсэл, ажил үйлчилгээг авсан.	100%


16	3.1.15.2	Ажлын хувцас, дээжний уутийг тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулан худалдан авах	Уурхайн ажилчдын нормын хувцас хөдөлмөр хамгааллын багаж хэрэгсэл тоног төхөөрөмж Улаанбаатар хотоос авч очсон. Шинээр ажилд авсан ажилчдад 6 сая төгрөгийн нормын хувцас хэрэглэлийг орон нутгийн захаас худалдаж авсан.	80%
17	3.1.15.3	Харуул хамгаалалтыг сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжинд давуу эрх олгох	Тус уурхайн гэрээт харуул хамгаалалтын Шонхор алба нь орон нутагт бүртгэлтэй Баянхонгор аймгийн аж ахуйн нэгж болно.	100%
18	3.1.16	Аж ахуйн үйл ажиллагааны ашгаас авах татвараас бусад татвар Орон нутагт төлвөл зохих татвар шимтгэл /газрын төлбөр, усны төлбөр, хог хаягдлын төлбөр/-үүдийг орон нутгийн төсөвт төлдөг байх	2022 онд Газрын төлбөрт 19,9 сая төгрөг төлсөн. Ус ашигласны төлбөр 45,0 сая төгрөг, хог хаягдлын хураамж 1.2 сая төгрөгийг орон нутгийн татварт төлж орон нутгийн төсөвт оруулсан.	100%
19	3.1.17	Ус ашигласны төлбөрийг тоолуураар хуулийн хугацаанд нь төлнө. Хэрвээ усны тоолуур суурилуулаагүй бол Эрх бүхий байгууллагаас баталсан дүгнэлтийг үндэслэн Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаатай ноогдуулалтын гэрээ хийж, төлбөрийг орон нутагт тушаана. Ус ашигласны төлбөрийг дүгнэлтээр төлөх тохиолдолд	Ус ашиглах тухай дүгнэлт гараагүй Тус байгууллагуудын хоорондох асуудал шүүхийн маргаантай байгаа болно.	

20	3.1.18	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөөнд тусгагдсан техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг бүрэн хийж гүйцэтгэх	Тухайн жилийн байгаль орчны хамгаалах менежментийн төлөвлөгөөний биелэлтээр 6 га талбайд дүйцүүлэн хамгаалах теникийн нөхөн сэргээлт, төлөвлөгөөт 8 га талбайд хийж Аймгийн нөхөн сэргээлтийг хүлээн авах коммист хүлээлгэн өгсөн. Биологийн нөхөн сэргээлт хийгээгүй.	100%
21	3.1.19	Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.18, 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэх	Ус ашиглуулах дүгнэлттэй холбоотой асуудлаар шүүхийн маргаантай байгаа.	
Гэрээний хэрэгжилтийн дундаж хувь			96 хувь	

ХЯНАСАН:
БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА:

ДҮГНЭСЭН:
ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХЭЛТСИЙН
ДАРГА:

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
'МОНГОЛБОЛГАРГЕО' ХХК-ийн
ЗАХИРАЛ:



Д.МӨНХСАЙХАН

Т.ХИШИГБААТАР

Д.ЛХАГВАСҮРЭН